



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 11393

Улаанбаатар хот

Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эвдэрч гэмтсэнээс цаашид ашиглах боломжгүй болсон, элэгдлийн хугацаа дууссан, эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 457,737,876.40 /дөрвөн зуун тавин долоон сая долоон зуун гучин долоон мянга найман зуун далан зургаан төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ /Б.Баянмөнх/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ /Б.Баянмөнх/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001169



Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2019 оны 10 сарын 11-ийн дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил			Хэмжээ нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХХК-н шийдвэр
		Ашигласан жил	Хэмжээ нэгж	Тоо хэмжээ							
	Машин, тоног төхөөрөмж										
1	Асфальт бетоны үйлдвэр Нийгата NP-600B	17	ш	1	457,737,876.40	457,737,876.40	457,737,876.40	457,737,876.40	-	татах	
	Машин, тоног төхөөрөмжийн дүн					457,737,876.40	457,737,876.40	457,737,876.40	-		
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн										
	Үүнээс: Худалдах хөрөнгө										
	Актлах хөрөнгө										
	Татан төвлөрүүлэх хөрөнгө										
	Худалдсанаас олох орлого										
	НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										